

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/078/НА-СТА-ТШЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХөрөнгө	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khenti@audit.gov.mn

2026.02.25 № 382

танай _____-ны № _____-т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-ОВОО
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА М.ШАРАВГАВАА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Орон нутгийн төсвийн татварын бус орлогыг Төрийн бус байгууллагын данс, байгууллагын нэмэлт дансанд төвлөрүүлэн зарцуулсан, нөөцийн барааны өвс, тэжээлийг анхан шатны баримтгүй зарлагдсан, НДШ-ийн тайланд цалин дутуу тайлагнасан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, түлш халаалтын зардлыг илүү төлсөн, шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг дутуу мэдээлсэн, төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүрт олон нийтэд нээлттэй мэдээлэх, төрийн албаны нөөцөөс нөхөх арга хэмжээ авдаггүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,321,987.7 мянган төгрөгийг төвлөрүүлэн гүйцэтгэлээр 85.2 хувь буюу 1,127,465.8 мянган төгрөгийг зарцуулж, 194,521.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 32,810.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 96.6 хувь буюу 31,733.1 мянган төгрөгийг зарцуулж, 1,077.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Аудитын гол асуудал

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 1,122,182.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 584,882.1 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 537,300.8 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага өгч, 6,308.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоолоо.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 105 зорилтын хүрээнд 238 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 88 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээш түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	78,928,644.13	139,054,168.67
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,213.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	1,213.00
3121	Төгрөг	-	1,213.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах		1,213.00
33	АВЛАГА	8,998,088.46	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,498,088.46	-
335	Бусад авлага	4,500,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	4,500,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	69,930,555.67	117,452,955.67
351	Түүхий эд материал	53,948,339.00	100,155,539.00
35110	Тусгай зориулалттай материал	53,948,339.00	100,155,539.00
354	Хангамжийн материал	15,982,216.67	17,297,416.67
35410	Бичиг хэргийн материал	1,515,000.00	1,913,700.00
35420	Аж ахуйн материал	14,467,216.67	15,257,216.67
35450	Барилгын засварын материал	-	126,500.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	21,600,000.00
36300	Тэжээлийн нөөц	-	21,600,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,336,460,905.48	6,294,779,266.10
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,336,460,905.48	6,294,779,266.10
392	Биет хөрөнгө	6,125,644,905.48	6,083,963,266.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,792,861,852.30	6,966,937,852.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,010,153,290.86)	(1,301,036,831.37)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	322,304,953.00	366,004,953.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(130,436,286.22)	(175,334,953.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	378,052,613.77	320,478,039.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(303,834,966.82)	(190,409,847.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	85,989,497.00	93,227,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,621,451.23)	(17,676,345.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	80,839,924.20	80,839,924.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(50,357,939.66)	(59,066,925.14)
393	Биет бус хөрөнгө	210,816,000.00	210,816,000.00
39301	Програм хангамж	280,000.00	280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(280,000.00)	(280,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	210,816,000.00	210,816,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,415,389,549.61	6,433,833,434.77
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,415,389,549.61	6,433,833,434.77
51	Засгийн газрын хувь оролцоо	6,415,389,549.61	6,433,833,434.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	337,839,474.00	337,839,474.00
51101	Өмч: - төрийн	337,839,474.00	337,839,474.00
512	Хуримтлагдсан үр дүн	5,790,251,744.79	5,808,695,629.95
51210	Өмнөх үеийн үр дүн	5,165,113,939.97	5,790,251,744.79
51220	Тайлант үеийн үр дүн	-	18,443,885.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зерүү	287,298,330.82	287,298,330.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,415,389,549.61	6,433,833,434.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,308,981,055.00	1,775,928,507.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,600,000.00	414,268,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,600,000.00	414,268,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,600,000.00	414,268,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,600,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	413,268,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,306,381,055.00	1,361,660,007.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,948,655.00	39,672,307.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,065,655.00	1,575,507.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,883,000.00	38,096,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,156,432,400.00	1,321,987,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,156,432,400.00	1,321,987,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,521,743,808.04	1,722,229,621.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,521,743,808.04	1,722,229,621.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,290,026,098.48	1,491,317,833.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	507,392,047.26	711,990,362.38
210101	Үндсэн цалин	303,189,606.74	370,522,690.77
210102	Нэмэгдэл	167,387,986.12	235,760,006.27
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,055,000.00	24,224,000.00
210104	Урамшуулал	-	22,916,945.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,759,454.40	58,566,720.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,666,431.59	89,382,174.10
210201	Тэтгэврийн даатгал	43,472,703.87	61,479,444.73
210202	Тэтгэмжийн даатгал	5,096,322.17	7,115,013.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,686,142.58	3,874,181.40
210204	Ажилгүйдлийн даатгал	2,476,301.39	3,380,654.16
210205	Эрүүл мэндийн даатгал	9,934,961.58	13,532,880.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,345,810.52	55,059,324.35
210301	Гэрэл, цахилгаан	20,503,873.10	33,936,684.35
210302	Түлш, халаалт	16,499,572.66	21,122,640.00
210303	Цэвэр, бохир ус	1,342,364.76	-
2104	Хангамж, бараа материалын зардал	50,911,779.70	32,202,366.65
210401	Бичиг хэрэг	4,830,200.00	3,756,900.00
210402	Тээвэр, шатахуун	38,429,379.70	22,555,788.65
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,224,000.00	3,619,678.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,332,200.00	2,174,000.00
2105	Нормативт зардал	862,600.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	862,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,284,050.01	17,748,283.18
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	550,000.00
210602	Тавилга	24,500.01	136,333.18
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	156,000.00
210604	Урсгал засвар	54,259,550.00	16,905,950.00
2107	Томилолт, зочны зардал	15,458,000.00	11,945,000.00
210702	Дотоод албан томилолт	15,458,000.00	11,945,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,218,840.00	104,403,709.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,724,209.00	101,963,288.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,008,623.00	431,460.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	72,508.00	532,126.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	36,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	495,000.00
210807	Газрын төлбөр	963,500.00	945,835.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	453,886,539.40	458,586,814.20

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,845,713.00	68,705,308.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	330,000.00	650,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	397,710,826.40	399,230,806.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	231,717,709.56	230,911,787.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,711,000.00	35,312,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	26,525,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,102,000.00	7,186,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,609,000.00	1,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	203,909,177.78	195,599,587.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	203,909,177.78	194,521,871.06
213404	Хөрөнгийн	-	1,077,716.92
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	97,531.78	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	97,531.78	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(212,762,753.04)	53,698,885.16
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,760,000.00	35,255,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,760,000.00	35,255,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,760,000.00)	(35,255,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(216,522,753.04)	18,443,885.16

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,308,981,055.00	1,355,798,507.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,600,000.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,600,000.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,600,000.00	1,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,600,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,306,381,055.00	1,354,798,507.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,948,655.00	32,810,807.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,065,655.00	2,378,736.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,883,000.00	30,432,071.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,156,432,400.00	1,321,987,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,156,432,400.00	1,321,987,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,144,285,997.00	1,355,797,294.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,144,285,997.00	1,355,797,294.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	908,068,287.44	1,124,885,506.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	507,715,737.60	708,229,442.15
210101	Үндсэн цалин	303,189,606.74	304,969,754.14
210102	Нэмэгдэл	167,387,986.12	298,723,423.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,055,000.00	26,305,528.94
210104	Урамшуулал	-	27,440,967.38
210105	Гэрээт ажлын хөлс	34,083,144.74	50,789,767.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,636,822.62	88,645,005.87
210201	Тэтгэврийн даатгал	47,443,094.90	61,085,486.79
210202	Тэтгэмжийн даатгал	5,096,322.17	7,141,575.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,686,142.58	3,726,296.35
210204	Ажилгүйдлийн даатгал	2,476,301.39	3,483,729.49
210205	Эрүүл мэндийн даатгал	9,934,961.58	13,207,917.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,345,810.52	55,059,324.35
210301	Гэрэл, цахилгаан	20,503,873.10	33,936,684.35
210302	Түлш, халаалт	16,499,572.66	21,122,640.00
210303	Цэвэр, бохир ус	1,342,364.76	-
2104	Хангамж, бараа материалын зардал	32,023,436.70	24,465,854.08
210401	Бичиг хэрэг	3,531,200.00	3,431,900.00
210402	Тээвэр, шатахуун	23,258,236.70	14,863,076.08
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,334,000.00	3,619,678.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,804,000.00	2,455,200.00
2105	Нормативт зардал	1,512,600.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,512,600.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,127,000.00	23,617,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,010,000.00	7,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	940,000.00	156,000.00
210604	Урсгал засвар	46,177,000.00	16,461,550.00
2107	Томиллолт, зочны зардал	15,458,000.00	11,945,000.00
210702	Дотоод албан томиллолт	15,458,000.00	11,945,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,556,614.00	141,021,471.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	130,995,983.00	138,581,050.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,008,623.00	431,460.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	72,508.00	535,626.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	32,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	516,000.00	495,000.00
210807	Газрын төлбөр	963,500.00	945,835.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,692,266.00	71,901,858.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,495,266.00	70,740,158.57

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,197,000.00	1,161,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	236,217,709.56	230,911,787.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,711,000.00	35,312,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	26,525,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,102,000.00	7,186,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,609,000.00	1,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	203,909,177.78	195,599,587.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	203,909,177.78	194,521,871.06
213404	Хөрөнгийн	-	1,077,716.92
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,597,531.78	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,597,531.78	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>164,695,058.00</u>	<u>1,213.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	164,695,058.00	1,213.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,213.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцроний
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,839,474.00	287,298,330.82	5,216,906,637.90		5,842,044,442.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,839,474.00	287,298,330.82	5,216,906,637.90	-	5,842,044,442.72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	573,345,106.89		573,345,106.89
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,839,474.00	287,298,330.82	5,790,251,744.79	-	6,415,389,549.61
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	337,839,474.00	287,298,330.82	5,790,251,744.79	-	6,415,389,549.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,839,474.00	287,298,330.82	5,790,251,744.79	-	6,415,389,549.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	18,443,885.16		18,443,885.16
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	337,839,474.00	287,298,330.82	5,808,695,629.95	-	6,433,833,434.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,314,487,700.00	1,127,465,828.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,314,487,700.00	1,127,465,828.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,278,120,500.00	1,092,153,628.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	772,448,300.00	708,229,442.15
210101	Үндсэн цалин	317,800,800.00	304,969,754.14
210102	Нэмэгдэл	325,839,500.00	298,723,423.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,016,000.00	26,305,528.94
210104	Урамшуулал	40,000,000.00	27,440,967.38
210105	Гэрээт ажлын хөлс	50,792,000.00	50,789,767.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,556,000.00	88,645,005.87
210201	Тэтгэврийн даатгал	65,658,100.00	61,085,486.79
210202	Тэтгэмжийн даатгал	7,724,500.00	7,141,575.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,862,200.00	3,726,296.35
210204	Ажилгүйдлийн даатгал	3,862,200.00	3,483,729.49
210205	Эрүүл мэндийн даатгал	15,449,000.00	13,207,917.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	120,618,600.00	55,059,324.35
210301	Гэрэл, цахилгаан	51,531,400.00	33,936,684.35
210302	Түлш, халаалт	61,746,700.00	21,122,640.00
210303	Цэвэр, бохир ус	7,340,500.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	26,330,200.00	22,661,964.00
210401	Бичиг хэрэг	4,000,000.00	3,431,900.00
210402	Тээвэр, шатахуун	14,999,900.00	13,059,186.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,478,200.00	3,619,678.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	245,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,607,100.00	2,455,200.00
2105	Нормативт зардал	1,807,100.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,807,100.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,528,300.00	11,887,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,585,200.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.00	156,000.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	11,731,550.00
2107	Томилолт, зочны зардал	13,000,000.00	11,945,000.00
210702	Дотоод албан томилолт	13,000,000.00	11,945,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	167,734,200.00	141,021,471.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	163,611,200.00	138,581,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	622,800.00	
210803	Даатгалын үйлчилгээ	434,300.00	431,460.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,400.00	535,626.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,600.00	32,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	740,400.00	495,000.00
210807	Газрын төлбөр	1,543,500.00	945,835.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,097,800.00	52,703,871.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,548,900.00	51,542,171.57
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,548,900.00	1,161,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,367,200.00	35,312,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,367,200.00	35,312,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,525,700.00	26,525,700.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,260,000.00	7,186,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,581,500.00	1,600,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,314,987,700.00	1,127,465,828.94
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,314,987,700.00	1,127,465,828.94
132001	Орон нутгийн төсвөөс	1,314,987,700.00	1,127,465,828.94
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,810,807.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,810,807.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,733,090.08
2104	Хангамж, бараа материалын зардал	1,803,890.08
210402	Тээвэр, шатахуун	1,803,890.08
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,730,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,730,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,199,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,199,200.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,077,716.92
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1,077,716.92
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,810,807.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,810,807.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,378,736.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	30,432,071.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад 584,882.1 мянган төгрөгийн 5 алдаг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардлыг 101,266.9 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.
- Цалингийн зардлыг 3 дугаар сараас эхлэн мөнгөн сууриар бүртгэж, 7,042.1 мянган төгрөгөөр илүү бүртгэснийг залруулав.
- Цалингаас суутгасан ХХОАТ-ы өглөгийн 829.4 мянган төгрөгийг зардалд бүртгэснийг залруулав.
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн барилга байгууламж 455,673.7 сая төгрөг, машин тоног төхөөрөмж 8,820.0 мянган төгрөг, тавилга, аж ахуйн эд хогшил 980.0 мянган төгрөгийн эхний үлдэгдэл дутуу бүртгэгдсэнийг залруулав.
- Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагын дагуу хандив, тусламжаар ирсэн 10,000.0 мянган төгрөгийн хивэг тэжээлийг нөөцийн барааны тайланд орлогоор бүртгэхдээ авлагын дансаар дамжуулан буруу бүртгэснийг залруулав.

Аудитаар илэрсэн 537,300.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 5 албан шаардлага хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

1. Түлш халаалтын зардлыг 1,408.2 мянган төгрөгөөр илүү төлсөн.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д "халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох", Эрчим хүчний сайдын 2021.07.22-ны А/129 тоот тушаалаар батлагдсан "Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай"-ын "В"-д "... Хэнтий ... аймгуудын төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангагддаг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр, бусад аж ахуйн нэгж байгууллагуудын халаалтын эхлэх хугацааг 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр" тогтоосныг мөрдөн ажиллаагүй байна.

2. Бараа материалын тайлангийн нөөцийн бараа данснаас 4,900.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг анхан шатны баримтгүй зарлагадсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

1. НДШ-ийн 12 дугаар сарын тайланд 9 хүний цалинг 6,163.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Хадлангийн зориулалтаар айл, өрхөд 20 га, аж ахуйн нэгж байгууллагад 100 га газрыг ашиглуулахаар гэрээ байгуулж, төлбөрийг Эко Баян-Овоо ТББ-ын төрийн банкны 250501858879 тоот дансаар дамжуулан 166 айлын 16,650.0 мянган төгрөгийг

байгууллагын нэмэлт төсвийн дансанд шилжүүлж, мөн дансанд 26 өрхөөс 2,600.0 мянган төгрөг, 3 аж ахуйн нэгжээс 3,121.5 мянган төгрөг нийт 22,371.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.9.2-т "орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;", 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Хадлангийн зориулалтаар айл, өрхөд 20 га, аж ахуйн нэгж байгууллагад 100 га газрыг ашиглуулахаар гэрээ байгуулж, төлбөрийг Эко Баян-Овоо ТББ-ын төрийн банкны 250501858879 тоот дансанд төвлөрүүлсэн.

Байгууллагын нэмэлт дансанд 26 өрхөөс 2,600.0 мянган төгрөг, 3 аж ахуйн нэгжээс 3,121.0 мянган төгрөг, Эко Баян-Овоо ТББ-аас 166 айлын 16,650.0 мянган төгрөг нийт 22,371.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.9.2-т "орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;", 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

4. Тус байгууллага нь төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тохиолдолд олон нийтэд мэдээлэхгүйгээр төрийн сангийн мэргэжилтэнг 6 дугаар сараас СА-ны дарга, бэлчээр, тэжээл, газар тариалан хариуцсан мэргэжилтэнг 9 дүгээр сараас байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, мал аж ахуй, үйлдвэрлэлийн технологи, үржил бүртгэлийн мэдээлэл хариуцсан мэргэжилтэнг 12 дугаар сараас хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, хүнс хариуцсан мэргэжилтэнгээр түр орлон гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ." гэснийг зөрчсөн байна.

5. Шилэн дансны нэгдсэн системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 280,987.0 мянган төгрөгийн 8 орлогын гүйлгээ, 12,000.0 мянган төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 169,471.0 мянган төгрөгийн 13 худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Аудитаар илэрсэн 34,842.8 мянган төгрөгийн санхүүгийн асуудлын зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул агдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Элэгдэл дутуу бүртгэсэн	1	101,266.9			1	101,266.9	1	101,266.9				
Цалингийн зардлыг мөнгөн сууриар хөтлөсөн.	1	7,042.1			1	7,042.1	1	7,042.1		-	-	-
Цалингаас суутгасан татварыг зардалд	1	829.4			1	829.4	1	829.4				
Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл зөрүүтэй	1	465,743.7			1	465,743.7	1	465,743.7				
Үнэ төлбөргүй авсан өвс тэжээлийг авлагаар бүртгэсэн	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0				
Дүн	5	584,882.1	-	-	5	584,882.1	5	584,882.1		--	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Татварын бус орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлэн зарцуулсан	1	22,371.0			1	22,371.0						
Анхан шатны баримтгүй нөөцийн барааг зарлагдсан	1	4,900.0	1	4,900.0								
Цалинг шимтгэлийн тайланд дутуу тайлагнасан	1	6,163.7			1	6,163.7						
Халаалтын зардал илүү төлсөн	1	1,408.1	1	1,408.1								
Дүн	4	34,842.8	2	6,308.1	2	28,534.7	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг бүрэн байршуулаагүй	1	462,458.0			1	462,458.0		
Дүн	1	462,458.0	-	-	1	462,458.0	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоог зарлаагүй	1	-			1	-		
Тендер зарлаагүй	1	40,000.0			1	40,000.0		
Дүн	1	40,000.0	-	-	1	40,000.0	-	-
Нийт дүн	3	502,458.0	-	-	3	502,458.0	-	-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 54-А2370448

Чингис хот

ХЭА-2026/078/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайлангийн нөөцийн бараа данснаас 4,900,000.00 (дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийн өвс, тэжээлийг анхан шатны баримтгүй зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Анхан шатны баримтгүй зарцуулсан 4,900,000.00 (дөрвөн сая есөн зуун мянга) төгрөгийг өвс, тэжээлийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй дарга М.Шаравгаваагаар төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын дарга М.Шаравгаваад хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 55-А2370448

Чингис хот

ХЭА-2026/078/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түлш халаалтын зардлыг 1,408,176.00 (нэг сая дөрвөн зуун найман мянга нэг зуун далан зургаа) төгрөгөөр илүү төлсөн байна.

Энэ нь Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11-д "халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох", Эрчим хүчний сайдын 2021.07.22-ны А/129 тоот тушаалаар батлагдсан "Халаалтын улирал эхлэх, дуусах огноог тогтоох тухай"-ын "В"-д "... Хэнтий ... аймгуудын төвлөрсөн болон төвлөрсөн бус дулаанаар хангагддаг эмнэлэг, сургууль, цэцэрлэг, орон сууцны халаалтын эхлэх хугацааг тухайн оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 15-ны өдрөөр, бусад аж ахуйн нэгж байгууллагуудын халаалтын эхлэх хугацааг 10 дугаар сарын 01-ний өдрөөр, дуусах хугацааг дараа оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр" тогтоосныг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн." гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Түлш халаалтын зардлаас илүү төлсөн 1,408,176.00 (нэг сая дөрвөн зуун найман мянга нэг зуун далан зургаа) төгрөгийг дарга М.Шаравгаваагаар төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын дарга М.Шаравгаваад хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 142-А2370448

Чингис хот

ХЭА-2026/078/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн системд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 280,987,000.00 (хоёр зуун наян сая есөн зуун наян долоон мянга) төгрөгийн 8 орлогын гүйлгээ, 12,000,000.00 (арван хоёр сая) төгрөгийн 2 зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 169,470,981.00 (нэг зуун жаран есөн сая дөрвөн зуун далан мянга есөн зуун наян нэг) төгрөгийн 13 худалдан авалтыг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"-ийг долоо хоногийн дотор мэдээлнэ гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансанд мэдээлбэл зохих мэдээллийг ил тод мэдээлдэггүй, хяналт тавьдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга М.Шаравгаваа, нягтлан бодогч Э.Уранбайгаль нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 143-А2370448

Чингис хот

ХЭА-2026/078/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас тарвага сэргээн нутагшуулах 40,000,000.00 (дөчин сая) төгрөгийн ажлыг "Амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гэрээ багц-1", "Амьтны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гэрээ багц-2" болгон 2 хувааж 20,000,000.00 (хорин сая) төгрөгөөр шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга М.Шаравгаваад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА



ХЭНГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 15

Дугаар 144-А2370448

Чингис хот

ХЭА-2026/078/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

НДШ-ийн 12 дугаар сарын тайланд 9 хүний цалинг 6,163,687.00 (зургаан сая нэг зуун жаран гурван мянга зургаан зуун наян долоо) төгрөгөөр дутуу тайлагнасан байна.


Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингийн санг нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд зөрүүтэй тайлагнадаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга М.Шаравгаваа, нягтлан бодогч Э.Уранбайгаль нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР
Б.АРИУНАА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 207 - А2370448

Чингис хот

ХЭА-2026/078/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагын Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тохиолдолд олон нийтэд мэдээлэхгүйгээр төрийн сангийн мэргэжилтэнг 6 дугаар сараас СА-ны дарга, бэлчээр, тэжээл, газар тариалан хариуцсан мэргэжилтэнг 9 дүгээр сараас байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, мал аж ахуй, үйлдвэрлэлийн технологи, үржил бүртгэлийн мэдээлэл хариуцсан мэргэжилтэнг 12 дугаар сараас хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, хүнс хариуцсан мэргэжилтнээр түр орлон гүйцэтгүүлсэн байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ." гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тохиолдолд олон нийтэд мэдээлдэггүй, нөөцөөс бүрдүүлдэггүй зөрчлийг арилган, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга М.Шаравгаваад даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА





ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25

Дугаар 208-А2370448

Чингис хот

ХЭА - 2026/078/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хадлангийн зориулалтаар айл, өрхөд 20 га, аж ахуйн нэгж байгууллагад 100 га газрыг ашиглуулахаар гэрээ байгуулж, төлбөрийг Эко Баян-Овоо ТББ-ын төрийн банкны 250501858879 тоот дансанд төвлөрүүлсэн.

Байгууллагын нэмэлт дансанд 26 өрхөөс 2,600,000.00 (хоёр сая зургаан зуун мянга) төгрөг, 3 аж ахуйн нэгжээс 3,121,500.00 (гурван сая нэг зуун хорин нэг мянга таван зуу) төгрөг, Эко Баян-Овоо ТББ-аас 166 айлын 16,650,000.00 (арван зургаан сая зургаан зуун тавин мянга) төгрөг нийт 22,371,000.00 (хорин хоёр сая гурван зуун далан нэгэн мянга) төгрөгийг төвлөрүүлж, зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.9.2-т "орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;" 35 дугаар зүйлийн 35.2-т "Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн төсвийн татварын бус орлогыг төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулаагүй, байгууллагын дансанд төвлөрүүлэн зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга М.Шаравгаваад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Б.АРИУНАА

